



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

2018 он 05  
сарын 21 өдөр

Дугаар 37-1/103

Улаанбаатар  
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ДАРГА М.ЭНХБОЛД ТАНАА

Тогтоолын төсөл өргөн  
мэдүүлэх тухай

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Мал эмнэлэг, үржлийн газрын нэрийг Мал эмнэлгийн ерөнхий газар болгон өөрчлөхтэй холбогдуулан боловсруулсан "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 16<sup>1</sup>.1-д заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар нэн яаралтай хэлэлцүүлж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд



У.ХҮРЭЛСҮХ

001669



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2018 он 05 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар Хэс/1076

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011


УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА Ц.ЦОЛМОН ТАНАА

Тов тогтоолгох тухай

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Мал эмнэлэг, үржлийн газрын нэрийг Мал эмнэлгийн ерөнхий газар болгон өөрчлөхтэй холбогдуулан боловсруулсан "Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд шийдвэрлэсний дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар нэн яаралтай хэлэлцүүлэхээр холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Монгол Улсын Сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР

005497

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны ... дугаар сарын...- ны өдөр      Дугаар ...      Улаанбаатар хот

### Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” хэсэгт “17.Мал эмнэлэг, үржлийн газар” гэснийг “17.Мал эмнэлгийн ерөнхий газар” гэж өөрчилсүгэй.

2. Энэ тогтоолыг 2018 оны ... дугаар сарын ... –ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ГАРЫН ҮСЭГ